

хэрэгтэй болдог, нэгэнт хөл дээрээ бүрэн босч, улмаар хөгжсөн орон болж эхэлмэгц шинжлэх ухаан, техник-технолого эрхбиш тэргүүлүүлэн түлхүү хөгжүүлж, түүндээ эдийн засгаа дагуулж хурдавчлан хөгжүүлэх нь зүй тогтол гэж бид үзэж байгаа юм гэсэн утгатай ярьж байв.

Энэ бүхнээс үзэхэд Солонгос, магадгүй бас Азийн барс болсон бусад улс орон хэрхэн яаж үсрэн хөгжиж, хөгжсөн орон болох тухай аль эрт өөр өөрийн үндэсний онол-арга зүйн суурь тавигдаж тус бүрийн нэгэнт хэрэгжүүлсэн бэлэн туршлагатай болсон байх бөгөөд тэр нь манайд ч гэсэн сургамжтай зүйл мэт санагдана.

1993.07.01.

ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ БҮС ЖУХАЙ

Ч. Батцэцэг*

Хятадын эдийн засгийн онцгой бүсийн нэг Жухай бол Гуандун мужийн өмнөд хэсгийн далайд цутгадаг томоохон голын сав газарт орших бөгөөд баруун талаараа Сувдан голын адаг, урдуураа Аомынь (Макао) -тэй хөрш зэргэлдээ оршино. Нийт 121 км² талбайтай. Далайн худалдааны замын ойролцоох байгалийн таатай нөхцөл, хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр гадаад ертөнцөд ойр дөтийг харгалзан Жухайг бусад гурван мужийн хамтаар 1980 онд албан ёсоор эдийн засгийн онцгой бүс (ЭЗОБ) болгон байгуулсан юм. Арван хоёр жилийн өмнө хоцрогдсон бөглүү, зөвхөн загасны аж ахуй эрхэлж байсан тосгон өдгөө хилийн чанадад алдартай орчин үеийн боомт хот болжээ.

Эхний хэдэн жилд үндсэндээ жуулчлалыг хөгжүүлэхэд гол анхаарлаа тавьж, жуулчлалын үйлчилгээний бүх системийг хөгжүүлж, Жухайгаас Гонконг, Шэньжэнь хүрэх боомтын (Цзючжоу) барилга байгууламж, нисэх онгоцны буудал, Гонконг, Макаотай усан болоод төмөр замын шууд харилцаа, усан ба цахилгаан хангамжийн систем, далайн эрэг дээр дээд зэргийн буудал, амралтын газар, аж үйлдвэрийн барилга байгууламжийг барьж эхэлжээ¹. 1984 оноос эдийн засгийн онцгой бүс Жухайгийн боломжийг бүрэн нээхтэй холбогдсон үзэл баримтлал боловсруулав. Ингэснээр зөвхөн жуулчлалыг хөгжүүлээд зогсохгүй гол үүрэг гүйцэтгэх бусад салбар аж үйлдвэр, жуулчлал-худалдаа, хөдөө аж ахуй, мал аж ахуй, төрөл бүрийн худалдааны барилга байгууламжийн бүхэл бүтэн аж ахуйн цогцолборыг байгуулахаар шийдвэрлэжээ. Шинжлэх ухаан техникийг үйлдвэрлэлтэй уялдуулан хөгжүүлэх чигийг баримталсан байна. Дэлхийн шинжлэх ухаан, техникийн ололт, олон улсын зах зээлийн өөрчлөлтийн тухай шуурхай мэдээлэл авахад гол анхаарлаа хандууллаа.

Жухайг «Шинжлэх ухааны хот» болгохоор шийдэж, юуны өмнө шинжлэх ухаан техникийн дэвшлийн хамгийн сүүлийн үеийн ололт амжилтанд хүрээгүйгээс гадаадын зах зээлд өрсөлдөж чадахгүй байна гэдгээ хятадын удирдагчид мэдэрчээ. Дараа нь Хятадын зах зээлд Шинжлэх ухаан техникийн үзэл санаа хараахан бодитоор бүрэлдээгүй, судалгааны үнэ цэнэтэй олон ажил үйлдвэрлэлд нэвтэрч чадахгүй байгааг бас анхаарчээ. Хэрвээ шинжлэх ухаан техникийн чадалтай хүчийг

* ДДОУС-ын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

уг бүс нутагтаа татан оруулъя гэвэл юуны өмнө ахуйн болоод хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах хэрэгтэй, өөрөр хэлбэл эрдэмтдийн «Оюуны хэрэгсэл» бидэнд нийгэм эдийн засгийн үр өгөөжөө өгч болох юм гэж дүгнэжээ. Ингээд Жухайгийн удирдлага шинжлэх ухаан техникийн ажилтан, эрдэмтэн мэргэжилтэн нарын ахуй амьдралыг сайжруулж, тэдний орон сууцанд зориулж 10 сая юань зарцуулан, дугаар баримтлахгүй орон байр олгох болов. Мөн онцгой шалгарсан эрдэмтэн мэргэжилтэн нарт урьд өмнө хэзээ ч байгаагүй тийм урамшуулал шагналын системийг бий болгосон нь бүхний анхаарлыг татаж, шинжлэх ухааныг хөгжүүлэхэд түлхэц болжээ.

Өнөөдөр жухайчууд тэргүүний шинжлэх ухаан техникт найдаж, энд эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн ажилтан мэргэжилтэн хэрхэн биеэ дайчилж хөдөлмөрлөхөөс бүх юм шууд хамаарч байна. Жухай цахим тоолуур, эмнэлгийн биобэлдмэл, цахилгаан-механик, техникийн салбараар Хятадад тэргүүлэх болов. Эрдэм шинжилгээ, судалгааны 300 гаруй ажил үйлдвэрлэлд нэвтэрчээ.

Эдийн засгийн онцгой бүс дэх гадаадын хөрөнгө оруулалт нь худалдаа аж үйлдвэрийн хоршооллын энгийн хэлбэрээс хувь нийлүүлэн хамтарсан үйлдвэр, гадаадын цогцолбор үйлдвэр хүртэл орчин үеийн олон улсын хөрөнгө оруулалт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны бараг бүх хэлбэрийг агуулжээ. Өнөөдрийн байдлаар Жухайд гадаадын болон хамтарсан үйлдвэрүүд гадаадын түншүүдтэй хамтран ажиллах зарчмаар байгуулагдсан үйлдвэрийн газар ойролцоогоор 2 мянга болоод байна. Энэ нь бүх үйлдвэрийн газрын 90 хувийг эзэлнэ. Эдгээр үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн жилийн өртөг 4 тэрбум юаньд хүрчээ. АНУ, Канад, Япон, Англи, Итали, Гонконг, Макао зэрэг 18 улс орон Жухайд хөрөнгө оруулж байна. Мөн бүс нутгийн (Тайван, Гонконг, Макао гэх мэт) хятад гаралтай, ажил хэрэгч хүмүүс, хоршоологчдын үр дүнд 800-гаад үйлдвэр байгуулагджээ. 1990 оноос Жухайд хөрөнгө оруулалт, боловсон хүчнийг нэмэгдүүлэх чиглэлээр хэд хэдэн цогцолбор арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн юм.

Гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй хөнгөлөлт эдийн засгийн онцгой бүсэд хөрөнгө оруулалтын ашигтай нөхцөл байдлыг бий болгоход чиглэгджээ. Гадаадын хөрөнгийг аль ч хэлбэрээр ашиглаж байгаа үйлдвэрийн газруудын нийт орлогын татвар 15 хүртэл хувь (БНХАУ-ын бусад мужид 30 хувь, Гонконгт 18,5 хувь) байна. Гадаадын хөрөнгө оруулсан үйлдвэрүүд тоног төхөөрөмж, түүхий эд, сэлбэг, тээврийн хэрэгсэл зэргээс авах гаалийн татвараас чөлөөлөгдөх юм. Гадаадын оролцоотой байгуулсан буюу технологийн өндөр хөгжилтэй үйлдвэрүүд өөрсдийн эдэлбэр газрын эзэмшилт, ашиглалтад 20—30 хувийн хөнгөлөлттэй татвар ногдуулсан бөгөөд эдгээрийн үнийг шууд бус хэсэг хэсгээр нь төлөхийг зөвшөөрчээ. Түрээслэн авсан үйлдвэрийн барилгын үнийг бууруулсны зэрэгцээ хувьдаа хөнгөлсөн үнээр авч болох ажээ. Гадаадаас хөрөнгө оруулж ирсний дараа онцгой бүсийн үйлдвэрийн бүтээгдэхүүний өртөг жил бүр 45 хувиар, гадаад худалдааны хэмжээ 52 хувиас дээш өсөж байна⁴. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд ЭЗОБ-ийн - нутаг дээр гадаадын банкуудын үйл ажиллагааг зөвшөөрч, хадгаламж хүлээж авах, зээл олгох орон нутгийн болон гадаадын валютаар хөрөнгө оруулалтыг гүйцэтгэх, Онцгой бүсэд гадаадаас валют оруулах, гаргах, гадаад худалдааны тооцооны үйлчилгээ гэх мэтийн аж ахуйн үүрэгтэй хятад-гадаадын хамтарсан банкуудыг байгуулжээ. Гадаадын банк Хятадын Ардын банкны орон нутгийн салбаруудын хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг.

Эдийн засгийн онцгой бүс Жухай эдийн засгийн үйл ажиллагаагаа гол төлөв зах зээлийн хуулиар зохицуулдаг. Мөн, түүнчлэн эдийн засгийн удирдлагын биеэ даасан эрхийг эдэлдэг юм. Жухай гадаадын хөрөнгө, тэргүүний техник, тоног төхөөрөмжийг татан оруулж, экспортын худалдааг өргөжүүлж, валютын орлого хуримтлалыг нэмэгдүүлэхийн сацуу гадаадын Шинжлэх ухааны ололт амжилтыг өөрсдөө судалж эзэмшээд дэлхийн эдийн засгийн хөгжлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боллоо. Дэлхийн зах зээл дээр Жухайгаас үндсэндээ 110 нэр төрлийн бараа, өндөр технологийн бүтээгдэхүүн гардаг. Статистикийн мэдээгээр зөвхөн 1991 оны эхний хагас жилд хот суурин газрын үйлдвэрийн бүтээгдэхүүний өртөг 3.33 тэрбум юаньд (628 сая ам. долл) хүрсэн нь 1990 оны мөн үетэй харьцуулбал 99,9 хувиар давжээ. Мөн 1991 оны эхний хагас жилд гадаадын хөрөнгө оруулах 291 гэрээ хийсэн нь өнгөрсөн оныхоосоо 103 хувиар өсчээ.⁵ Жухайд хөдөөгийн үйлдвэрийн газруудын 90-ээд хувь нь удирдлагын хариуцлагын системийг хэрэгжүүлж, хариуцан авах (гадаад худалдааг хариуцан авахыг багтаасан арга барилаар ажилласнаар, үйлдвэрийн газрын удирдлага аажмаар сайжирч, хэв журамтай, тогтвортой болжээ. Үүний зэрэгцээ хөдөө тосгоны үйлдвэрийн газарт гаднаас тэргүүний техник татан оруулж, үйлдвэрлэлд тохиромжтой бүтээгдэхүүнийг нийлүүлж байна. Гар ажиллагаатай үйлдвэрийг аажмаар механикжуулж, автоматжуулснаар хөдөлмөрийн бүтээмж эрс дээшилжээ⁶.

Ийнхүү өнгөрсөн арван жилийн хугацаанд эдийн засгийн онцгой бүс Жухай асар их хөгжлөө. Орчин үеийн загвар хийцтэй тансаг гоё буудал, барилгаар дүүрсэн байгалийн үзэмж төгөлдөр энэхүү далайн арал гадаад, дотоодын жуулчдын анхаарлыг өдрөөс өдөрт татаж байна. 1980—90 онд гадаадын 180 сая жуулчныг хүлээн авч 1 тэрбум 900 сая юанийн орлого олжээ. 1991 онд аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийт өртөг 10,94 тэрбум юаньд хүрсэн нь 1980 оны үзүүлэлтээс 23 дахин их болжээ.⁸ Жухайд цахилгаан, нэхмэл, хүнс, хөнгөн ба хими, эмийн үйлдвэр зэрэг хөгжилтэй томоохон үйлдвэрүүд ажиллаж байна. Энд орон сууцны барилгууд олноороо баригдаж, нэг хүнд дунджаар 12 м² талбай, 6 хүн тутамд нэг харилцах утас: ногдож байна.

Жухай хотын засаг захиргаанд харьяалагдах нутаг дэвсгэрийн бүх хүн ам 520 мянгаас давжээ. Үүнээс 230 мянга нь хот суурин газар амьдардаг. Жухай хотыг эдийн засгийн онцгой бүсийн «алтан төв» хэмээн нэрлэдэг. Учир нь Жухай хот нэг хүнд ногдох болон үндэсний нийт бүтээгдэхүүний дундаж тооцоогоор үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өртөг, хөдөлмөрийн бүтээмжээрээ Хятадын далайн эргийн нээлттэй 30-аад хотын дотор дээгүүр байр эзэлдэг.

Эдийн засгийн хөгжлийг хурдасгахдаа жухайчууд байгаль экологийн тухай мартаагүй ээ. Энэ маш чухал асуудал юм. Урьд өмнө Хятадын бүх нутаг дотроо Жухайгийн агаар, хөрсөн дээрх ус бараг, хамгийн их бохирдсоц байлаа. Одоо бол байдал огт өөр, хүрээлэн буй орчны чимээ шуугианд ч хүртэл хяналт тавих болжээ. Өнгөрсөн 12 жилийн хугацаанд Жухайд зам тээврийг хөгжүүлэх хийгээд хотын ногоожуулалтанд 2 тэрбум юань зарцуулав. Жухай одоо хятадын хамгийн цэвэр, ногоон хотуудын нэг болж, хотын нэг иргэнд дунджаар 14 м² ногоон таримал талбай ногдож байна.

Эдийн засгийн онцгой бүс Жухайг хөгжүүлэх 90-ээд оны хэтийн төлөв бол гадаад ертөнцрүү эдийн засгаа чиглүүлж, үйлдвэрлэлийн бүтцийг сайжруулахын тулд бүхий л хүчээ төвлөрүүлэхэд оршино. Дараагийн алхам нь эрчим хүч, түүхий эдийн бааз, зам тээвэр, харилцаа

холбоог хөгжүүлэх, суурь болоод хүнд үйлдвэр, химийн үйлдвэрийн салбарын үндэс суурийг тавьж, шинжлэх ухаан техникийн ололтыг үйлдвэрлэлтэй хослуулна. Дэлхийн бүхий л улс оронтой техник эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд цаашдаа гадаадын хөрөнгө оруулалтыг бүхий л талаар сайжруулна. Эдийн засгийн Онцгой бүс Жухай 2000 он гэхэд хүн амын нэг хүнд ногдох үндэсний орлого, аж үйлдвэрийн нийт өртөг, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ дэлхийн дунд хөгжилтэй орны төвшинд хүрэх зорилготой ажээ.

БНХАУ-д Эдийн засгийн онцгой бүс нээж ашигласан туршлагаас үзэхэд дэд бүтцийг хөгжүүлэхэд онцгой анхаарч, гадаад дотоодын эрдэмтдийн саналыг нэгтгэн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан байна. Түүнд газарзүйн ашигтай байрлал, зам тээвэр, төлөвлөлт, ерөнхий стандарт, газар доорх байгууламж, янз бүрийн бүс нутгийн үйлдвэрлэх хүчний байршлыг тогтоох, барилгын зураг төслийг хянах, эдийн засгийн шаардлагатай нөөц, ажиллах хүч, түүхий эд болон ногоожуулах чиглэлээр нэгдсэн бодлогоо явуулахаар тусгасан байна. Ийнхүү төлөвлөснөөр үргүй зардал гарахаас урьдчилан сэргийлж, сайн үр дүнд хүрчээ.

Эдийн засгийн Онцгой бүс байгуулахад хөрөнгө оруулалт ихээр шаардагдахыг харгалзан тэдгээрийн эх үүсвэрийн хэмжээ, санхүүжүүлэх журам, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалтын нөөцийг ашиглах талаар баттай мэдээлэлтэй байх хэрэгтэй юм. Нийгмийн байдал харьцангуй тогтвортой таатай болсон үед цаг алдалгүй бүхий л боломжийг ашиглаж бүх салбарт өөрчлөн байгуулалт хийх нь зүйтэй. Энэ нь өөрчлөлт шинэчлэлтийн гарч болзошгүй алдаанаас зайлсхийж, өөрчлөлт шинэчлэлтийг түр хойшлуулах хэрэгтэй гэж Хятадын эрдэмтэд үзжээ.

Гадаадын хөрөнгийг үр ашигтай зарцуулах, үндэсний үйлдвэрүүд олон улсын хамтын ажиллагаанд оролцох сонирхол нь зөвхөн «гадаадад нээлттэй байхаас» гадна бас улсын аж ахуйн механизмд таваар мөнгөний харилцааны бүх талын хөгжлийг тусгах, хүнд сурталт удирдлагаас салах, аж ахуйн шууд харилцааны өргөн хүрээтэй систем бүрдүүлэх зэрэг өөрчлөлт хийх шаардлагатайг Хятадын туршлага харуулж байна. Энэ нь өнөөдөр эдийн засгийн нээлттэй бодлого явуулж, чөлөөтэй бүс байгуулна хэмээн ярьж буй манай Монгол улсын хувьд зарчмын чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. «Энциклопедия нового Китая» 1989 г., с. 338-339
2. «Китай» сэтгүүл 1992 № 8 с. 8.
3. «Жэньминь жибао» 1991. 3. 12
- 4 Мөн тэнд
5. «China Statistics» 1991, № 4
6. «Жэньминь жибао» 1991. 01. 09
7. «Цзинцзи жибао» 1991. 11. 11
8. «Китай» 1992. 03. 08
9. «China Daily» 1991. 11. 13